



МОНГОЛ УЛС
ХЭНТНИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 24 өдөр

Дугаар А/454

Чингис хот

Хяналт шалгалтын гост ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.3а, Засгийн Газрын 2019 оны 43 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.3, 7.5.1, 7.5.2, 7.5.3, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. "Хяналт шалгалт-2020" нэгдсэн арга хэмжээний хүрээнд өөр аймаг, сумаас отроор орж ирж буй малчин, малын хөдөлгөөнд хяналт тавих зорилгоор Цэнхэрмандал сумын нутаг Хэрлэн голын гүүрэнд пост гаргаж 2020 оны 09 дүгээр сарын 28-аас 10 дугаар сарын 28-ыг хүртэл хугацаагаар цагдаагийн газрын ажилтан, Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч нарыг ажиллуулахыг Цагдаагийн газрын дарга /Н.Батсайхан/, Мал эмнэлгийн газрын дарга /Н.Анхбаяр/ нарт үүрэг болгосугай.

Хоёр. Малыг гоц халдварт овчингүй тайван бүс нутгаас ирсэн мал амьтныг нэвтрүүлэхдээ Засгийн Газрын 2019 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулж, мал эмнэлгийн цахим гэрчилгээтэй халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт болон шимэгчлэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан мал амьтныг нэг бүрчлэн эрүүл мэндийн үзлэгт хамруулах ба гэрээнд заасан газраас өөр нутагт ирсэн малыг хүлээж авахгүй буюу шаардлагатай тохиолдолд хязгаарлалтын дэглэм тогтоож гоц халдварт, халдварт өвчний шинжилгээ хийж эрүүлийг баталгаажуулахыг Мал эмнэлгийн газар /Н.Анхбаяр/, Сумдын Засаг дарга, Мал эмнэлгийн улсын байцаагч нарт даалгасугай.

Гурав. Хяналт шалгалтын постны үйл ажиллагаанд шаардагдах 1667500 /нэг сая зургаан зуун жаран долоон мянга таван зуун/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн урьдчилан тооцох боломжгүй нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д зөвшөөрсүгэй.

Дөрөв. Хяналт шалгалтын постын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ДАРГА

Ц.ИДЭРБАТ



231010309

09 Аймгийн Засаг даргын 2020 оны
дугаар сарын 24 өдрийн А/1154
дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТОЦОО

№	Төрөл	Нэгжийн үнэ	Тоо хэмжээ	Нийт дүн
1	Урамшуулал	200000	2хүн	400000
	Томилолт	16500	2 хүн/30 хоног	990000
	Шатахуун	1850	150 л	277500
Нийт дүн				1667500